

20MPH Сургуулийн хурдны хязгаарын бүсчлэл: Одооноос хэрэгжиж эхэллээ.

Сургууль орчмын хурдны хязгаарлалтын бүс гэж юу вэ?

Сургууль орчмын хурдны хязгаарлалтын бүс гэдэг нь сургуулийн гол хаалганаас 600 футийн зайд **буй гудамжинд цагийн 20 милийн хурдтай явах хязгаарлалтыг хэлдэг**. Арлингтон тойргоос 2022 оны эхээр 11 төрийн өмчит, 2 хувийн сургуульд [Сургууль очмын хурдны хязгаарлалтын бүсийн туршилтыг](#) хийсэн билээ.


Эдгээр Сургууль орчмын байнгын хурдны хязгаарлалттай бүсүүдэд буй хурдны хязгаарыг сургууль ажиллагаатай байгаа эсэхээс үл хамааран бүтэн өдрийн туршид байнга мөрдөх юм.

Сургууль орчмын хурдны хязгаарлалтын бүсчлэл нь Арлингтон тойрогт хэрэгжүүлж буй аюулгүй байдлын шинэ арга хэмжээ бөгөөд уг туршилтаар бүх сургуульд хэрэгжүүлэхийн өмнө энэхүү бүсчлэлийн бодлого нь сургууль орчмын хурдыг багасгахад хэр үр нөлөөтэй байгааг шалгах юм.

Та үүнд хэрхэн хувь нэмрээ оруулж чадах вэ?

Та үүнд дараах арга замаар оролцож болно:

1. **Хурдлын хязгаарлалтыг дагах:** Хүүхдээ хүргэх эсвэл зүгээр сургуулийн орчмоор машинаараа явах үедээ хурдны хязгаар **20MPH-тай явах нь осол гаргах эрсдлийн ихээр бууруулахыг санана уу.**
2. **Энэхүү материалыг бусадтай хуваалцах:** Сургууль орчмын хурдны хязгаарлалт нь нийтийн аюулгүй байдлыг сайжруулж, сургууль руу аюулгүй хүрэх замыг баталгаажуулах талаар бусдад дамжуулаарай.
3. **Stay tuned:** Энэ хаврын төгсгөлөөр энэхүү хязгаарлалтын туршилтын талаар бид иргэдийн саналыг авах бөгөөд [Vision Zero website](#). вэбсайтад зочилж шинэ мэдээлэл авч Vision Zero сар бүрийн мэдээллийн сониныг маань захиална уу.



Сургууль орчмын хурдны хязгаарлалтыг хаана хийсэн бэ?

Одоогийн байдлаар сургууль орчмын хурдны хязгаарлалтын туршилтыг дараах сургуулиудад хийсэн болно. (эндээс газрын зураг үзнэ үү)


- Арлингтоны Уламжлалт Бага Сургууль
- Кардиналын Бага Сургууль
- Дрю Бага Сургууль
- Эскуэлэ Кий Бага Сургууль
- Глөүб Бага Сургууль
- Ганстоны Дунд Сургууль
- Хоффман Бостоны Бага Сургууль
- Инновэйшн Бага Сургууль
- Ст Томас Мур Бага ба Дунд Сургууль
- Такахөү Бага Сургууль + Бишоп О'Коннелийн Ахлах Сургууль *
- Уэйкфильд Ахлах + Клэрмонтын Бага Сургууль *

**нийлүүлсэн сургуулиудын бүсчлэлийг заана.*




20MPH Хурдны хязгаарлалтын тэмдэг 24/7 хэрэгжинэ.

Сургууль орчмын хурдны хязгаарлалт ямар харагдах вэ?



Зам гарах тэмдэг

Харагдац сайтай зам гарах тэмдэглэгээ



Хурдны хязгаарын тэмдэглэгээ